



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

**Зам, тээврийн хөгжлийн яам**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ,  
дотоод аудитын газар

## **ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦИЙН 2018 ОНЫ ХУДАЛДАН АВАЛТАНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019.01.04

Зам, тээврийн хөгжлийн Сайдын баталсан удирдамжийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаас 2018 онд зохион байгуулсан худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлах журам”, Сангийн сайдын 2008 оны 249 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зөвлөх үйлчилгээний үнэлгээний заавар”-ыг удирдлага болгон хяналт шалгалтыг явууллаа.

Хяналт шалгалтын хамрах хүрээ: Зам, тээврийн хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Иргэний нисэхийн ерөнхий газар”-ын 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон худалдан авалтыг санхүүжилтийн эх үүсвэр бүрээр батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн тоо мэдээ, биелэлтийн хувьд үндэслэн хийлээ.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад **нийт 342,984.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 төсөл арга хэмжээний жагсаалт баталснаас 2018 оны санхүүжилтэнд 80.796.9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.**

Үүний 60 төсөл буюу **93.7 хувь** нь авто замын салбарт, 3 төсөл буюу **4.7 хувь** нь тээврийн салбарт, 1 төсөл буюу **1.6 хувь** нь техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/, зураг төсөв боловсруулах чиглэлээр хуваарилагдсан байна. Мөн **авто замын салбарт** хуваарилсан 2018 оны санхүүжилтийн **69,296.95 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй 60 төслөөс 42 арга хэмжээ буюу 70 хувь нь авто замын барилга байгууламж барих **хөрөнгө оруулалт**, 18 арга хэмжээ буюу 30 хувь нь **авто замын их засварын ажлын хөрөнгө оруулалт** байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад 2018 онд **Улсын төсвөөс** санхүүжүүлэхээр батлагдсан 64 төсөл арга хэмжээний санхүүжүүлэлтэд **80,796.9 сая** төгрөг батлагдсан бол **урсгал төсвөөс 3 төсөл арга хэмжээнд 195.0 сая** төгрөгийн төсөв, **Гадаадын зээлийн** хөрөнгө оруулалтын **10,456.2 сая** төгрөгт хэрэгжих **3 төсөл**,

ИНЕГ-т хэрэгжих **10** арга хэмжээ нийт **79** төсөл арга хэмжээний санхүүжилт батлагдсан байна. Дээрх 79 төсөл арга хэмжээг 83 багцад задлан тендерийг зохион байгуулсан.

Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 64 төсөл арга хэмжээнээс он дамжин хэрэгжсэн /шилжих/ 12 төсөл арга хэмжээнд 23,727.2 сая төгрөгийн санхүүжилт баталснаас 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 9 арга хэмжээний санхүүжилтэд 11,810.13 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 49.8 хувийн санхүүжилтийг хийсэн.

Зам, тээврийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжих 52 төсөл арга хэмжээний 3 төсөл арга хэмжээний худалдан авалтыг хийхэд тендер зарлах шаардлагагүй гэж үзсэн байна. Үүнд:

1. /XIV.1.2.2/ *“Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалт /улсын хэмжээнд/”* 20.0 тэрбум төгрөгийн төсөв өртөгтэй төсөл, арга хэмжээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-д *“Улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй”* гэсэн заалтыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулах шаардлагагүй байна.

2. /XIV.1.1.11/ *“Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр 2018-2020 онд хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих 4,843.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/”* төсөл, арга хэмжээ нь Сангийн яам, Хятадын Экспорт-Импорт банкны хооронд төслийн ажлыг эхлүүлэхэд шаардлагатай “тусгайлсан зээлийн хэлэлцээр”-ийн явцад шийдвэрлэх тул тендер зарлаагүй байна.

3. /XIV.1.1.27/ *“Зуунмод багийн 3.5 км, Баянхошуу багийн 2.5 км авто замын үлдэгдэл санхүүжилт /Төв, Зуунмод сум/”* төсөл, арга хэмжээ нь Авто замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжсэн төсөл тул арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийн төсөв батлагдсан байна. Иймд тендер шалгаруулалт явуулах шаардлагагүй.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан шинээр хэрэгжих 49 төсөл арга хэмжээг [tender.gov.mn](http://tender.gov.mn) сайтад байршуулж тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолыг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2017 оны 258/A/195 дугаар хамтарсан тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны “Төлөвлөгөө батлах тухай” 269 дүгээр тушаал, 2018 оны “Эрх шилжүүлэх тухай” 9 дүгээр тушаалаар тус тус 2018 оноос хэрэгжих зарим төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Нийт зарлагдсан төсөл арга хэмжээний 16 арга хэмжээ буюу 32.6 хувийг нийслэл, аймгийн засаг даргад зохион байгуулах эрхийг шилжүүлсэн бол, Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэрэгжлийн байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /ТӨБЗГ/-т 18 арга

хэмжээ буюу 36.7 хувийг болон, ТӨБЗГ-ын орон нутаг дахь салбарт эрх нь шилжилж зохион байгуулагдсан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 62 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15,189.4 сая төгрөгийн нийт өртөгтэй 16 төсөл арга хэмжээг /2018 оны батлагдсан санхүүжилт 7,278.5 сая төгрөг/ нийслэл, аймаг, орон нутгийн Засаг даргад эрхийг нь шилжүүлснээс 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь шилжүүлсэн арга хэмжээний 93.7 хувь байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар/ТӨБЗГ/-ын даргын хамтарсан 258/А/195 дугаар тушаалаар ТӨБЗГ-т эрхийг нь шилжүүлсэн 11 төслийн 9 төсөлд, ТӨБЗГ-ын орон нутаг дахь салбарт эрх нь шилжсэн 7 төслийн 4 төсөл, нийт 18 төслийн 13 төсөл арга хэмжээний шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь ТӨБЗГ-т шилжсэн төсөл арга хэмжээний 72.2 хувьд гэрээ байгуулан хэрэгжүүлж байна.

ЗТХЯ-наас хэрэгжүүлэх улсын төсвийн 16, Сангийн яамнаас шилжүүлж ирүүлсэн 10, он дамжин хэрэгжих 1, Зам, засвар арчлалтын 2, урсгал төсвөөс санхүүжих 3, Гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 3 нийт 35 төсөл арга хэмжээнээс 23 төсөл арга хэмжээний сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдсан байна.

Нийт дүнгээрээ Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад батлагдсан улсын төсөв, урсгал зардлын төсөв, гадаадын зээлийн хөрөнгө гэсэн 3 эх үүсвэрээр санхүүжих шилжсэн болон шинээр хэрэгжих 79 төсөл арга хэмжээний 59 багцад сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь 76.8 хувь байна.

Харин БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Гацууртын уулзвараас Налайх Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төслийн Монголын талын хөрөнгө Сангийн яам, БГХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулаагүй байгаа тул энэ төслийн тендер шалгаруулалт явагдаагүй байна.

Мөн тендер зарласан боловч хэрэгжилт дутуу 12 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Гомдол гаргасан тендер – 4
- Тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин зарлахаар болсон -1
- Тендер шалгаруулалт зарласан, хугацаа болоогүй төсөл - 1
- Тендерийг дахин зарласан -2
- Шууд гэрээ байгуулахаар болсон - 2
- Шууд гэрээ байгуулах хэлэлцээр амжилтгүй болсон – 2 байна. Үүнд:

**1. Сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэх шатанд Сангийн яаманд гомдол гаргасан 2 төсөл. Үүнд:**

1. /XIV.1.1.24/ Халуун усны байрнаас Их наран, Их нарангаас Буяны зам хүртэлх хатуу хучилттай авто зам, 1.2 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл, арга хэмжээ, мөн /XIV.1.1.25/ Баянбулагийн 2 дугаар гудамжнаас Мандал овооны 3 дугаар гудамж хүртэлх хатуу хучилттай 1.5 км авто зам /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, “Багануур-Мөнгөн морьт чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөл” “Норовлин-Дадал чиглэлийн 70 км авто замын зураг төсөл” гэсэн нийт 4 төсөл, арга хэмжээний тендерүүдийг үнэлгээний хорооноос үнэлж шалгарсан оролцогчид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэх шатанд Сангийн яаманд гомдол гарсан тул тендер шалгаруулалтыг түр түдгэлзүүлсэн байна.

## **2. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул дахин зарлахаар болсон төсөл арга хэмжээ**

1. /XIV.1.1.12/ Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг "Ростов" ХХК-иас боловсруулсан зураг төслийн дагуу 2018.08.20-ны өдөр зарлаж 2018.09.20-ны өдөр нээсэн. Үнэлгээний хорооноос тендерийг үнэлсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй гэсэн үндэслэлээр Үнэлгээний хорооноос тендер шалгаруулалтыг бүхэлд нь хүчингүй болгосон байна.

2. /XIV.1.1.33/ Орхон голын гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2018.04.06-ны өдөр зарлаж 2018.05.09-ны өдөр нээхэд оролцогчдын ирүүлсэн санхүүгийн санал батлагдсан төсвөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д заасныг үндэслэн бүх тендерээс татгалзсан. Тендер шалгаруулалтыг 2018.09.10-ны өдөр дахин зарлаж 2018.10.10-ны өдөр тендерийг нээсэн боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй тул Үнэлгээний хорооноос тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон байна.

## **3. Тендерийг шалгаруулалтыг зарласан, нээх хугацаа болоогүй байгаа төсөл арга хэмжээ**

/XIV.1.1.23/ Ханын материал орчмын орон сууцны хорооллын доторх хатуу хучилттай авто зам, 0.93 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний зураг төсөл бэлэн болж, магадлалын дүгнэлт гарсан тул уг тендерийг 2018.10.17-ны өдөр зарласан бөгөөд тендер нээх хугацаа 2018.11.19-ны өдөр буюу хяналт шалгалтад хамрагдах хугацаанаас хойш нээхээр байна.

## **4. Тендер амжилтгүй болсон тул дахин зарласан төсөл, арга хэмжээ**

1. /XIV.1.1.36/ Мандалын голын төмөр бетон гүүр, 62 у/м /Баянхонгор, Галуут сум/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2018.03.05-ны өдөр зарлахад оролцогчдоос шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д заасныг үндэслэн бүх тендерээс татгалзаж дахин нээлттэй тендер шалгаруулалтыг 2018.10.05-ны өдөр зарлаж тендер хүлээн авч байна.

2. /XIV.1.2.9/ *Хорооллын доторх авто замын засвар, 3 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/* төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2018.03.06, 2018.07.20-ны өдөр тус тус зарласан боловч 2 удаа тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Иймд Захиалагч Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 345 дугаар тушаалаар дахин байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д заасныг үндэслэн дахин нээлттэй тендер шалгаруулалтыг 2018.10.19-ны өдөр зарласан. Тендерийг 2018.11.20-ны өдөр нээжээ.

#### **5. Шууд гэрээ байгуулахаар төлөвлөж буй төсөл, арга хэмжээ**

/XIV.1.2.13/ *Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий аймгийн, Дадал, Баян-Адарга сум/* төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2018.03.02, 2018.05.25-ны өдөр тус тус зарласан. Тендер шалгаруулалтад шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул тендерийг 2 удаа хүчингүй болгосон. Үнэлгээний хорооноос шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүсэн байна.

#### **6. Шууд гэрээ байгуулах хэлэлцээр амжилтгүй болсон төсөл, арга хэмжээ**

/XIV.1.2.18/ *Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72.0 у/м /Увс, Улаангом сум/* төсөл, арга хэмжээнд тендер шалгаруулалтыг 2018.03.02-ны өдөр болон 2018.07.10-ны өдөр тус тус зарласан. Тендер шалгаруулалтад шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул тендерийг 2 удаа хүчингүй болгосон. Үнэлгээний хорооноос хуулийн дагуу шууд гэрээ байгуулахаар 2018.09.11-ны өдөр 4 байгууллагад шууд гэрээ байгуулах урилга хүргүүлж 2018.09.24-ний өдөр хүртэл саналын хугацааг тогтоосон боловч нэг ч оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулах боломжгүй болсон байна.

XIV.1.1.27/ *Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын нүхэн гарц /Дархан-Уул, Дархан сум/* төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2018.03.06, 2018.05.25-ны өдөр тус тус зарласан байна. Тендер шалгаруулалтад шаардлага хангасан нэг ч оролцогч ирээгүй тул тендер шалгаруулалт 2 удаа хүчингүй болсон. Үнэлгээний хороо болон “УБТЗ” ХХН-ийн төлөөлөл шууд гэрээ байгуулахад оролцох эрх бүхий оролцогчдыг сонгохоор хурлаар “УБТЗ” ХНН-ээс уг ажлыг хийх боломжгүй болохыг мэдэгдсэн. Мөн “УБТЗ” ХНН-ээс төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байршилд өвлийн улиралд хөрсний овойлт гарах, зуны улиралд төмөр замын даланд суулт өгөх, мөн бороо ихтэй үед хонгилон гарц усаар дүүрэх магадлалтай, мөн уг газар дээр удаан хугацаагаар галт тэрэгний хөдөлгөөнийг хаах боломжгүй тухай тус яаманд 2018.08.16-ны өдрийн 13/289 тоот албан бичгээр мэдэгдсэн байна.

Мөн Сангийн сайдын тушаалаар Зам, тээврийн хөгжлийн яаманд эрх шилжиж ирсэн 10 зөвлөх үйлчилгээний төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулж, 1 төсөл арга хэмжээний зураг төсөлд өөрчлөлт оруулахаар болж тендер шалгаруулалт явуулах шаардлагагүй болсон, 4 төсөл арга хэмжээний хамгийн

сайн оноо авсан гүйцэтгэгчид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн өгсөн бол, 2 төсөл арга хэмжээнд Сангийн яаманд гомдол очсон тул түдгэлзүүлсэн байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад 2018 онд санхүүжих **нийт 80.796.9 сая** төгрөгийн төсөвтэй **64 төсөл**, арга хэмжээнээс 2018 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар шилжих болон шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд нийтдээ **46,649.44** сая төгрөгийн санхүүжилтийг хийж батлагдсан төсвийн 57.7 хувийг зарцуулсан байна.

Үүнээс 2018 оноос шинээр хэрэгжиж эхлэсэн 31 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар төслийн гүйцэтгэлээр батлагдсан төсвийн 61.0 хувийн санхүүжилтийг хийсэн байна.

## **Хоёр. Иргэний нисэхийн ерөнхий газар**

Иргэний нисэхийн ерөнхий газар нь улсын төсвийн хөрөнгөөр болон байгууллагын цэвэр ашиг, урсгал зардлын эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу өмнөх оноос шилжсэн хөрөнгө оруулалтыг уламжлалт аргаар, 2018 онд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг цахим хэлбэрээр тендер зохион байгуулж ажилласан байна.

### **2.1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжих төсөл арга хэмжээ:**

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын XIV.2.1.1, XIV.2.1.2 дах заалтад *Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Засгийн газрын 2015 оны 313 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх авто зам/ /Төв, Сэргэлэн сум/, Дээлий цагаан нисэх онгоцны буудлын явгалах замын өргөтгөл /Увс, Улаангом сум/ гэсэн 2 төсөл арга хэмжээний санхүүжилтэнд 10,500.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.*

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.3.13-ны өдрийн “Төсөл арга хэмжээний жагсаалт батлах тухай” 44 дүгээр тушаал, 4 дүгээр сарын 25-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тушаалаар Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Засгийн газрын 2015 оны 313 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх авто зам/ -ний жагсаалтыг баталсан байна. Батлагдсан жагсаалтаар ИНЕГ-ын хариуцан хэрэгжүүлэх 5,465.3 сая төгрөгийн төсөвтэй 6 төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулж санхүүжүүлэн ажилласан байна. Энэхүү 6 төсөл арга хэмжээг 16 багц болгон цахимаар нээлттэй тендер зарлаж хэрэгжүүлснээс 11 багц ажил хэрэгжиж 1,831.1 сая төгрөгийн

санхүүжилт олгогджээ. Энэ нь нийт санхүүжилтийн 33.5 хувь нь болж байгааг хүснэгтээр харуулбал: /сая төгрөгөөр/

### Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл

№	Төсөл арга хэмжээний нэр	Төлөвлөсөн		Гэрээ байгуулсан		Гүйцэтгэл		Санхүүжилтийн хувь
		Төсөл тоо	өртөг	тоо	Гэрээний үнэ	Төсөл тоо	санхүүжилт	
1	Улаанбаатар хотод Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн хүрээнд Монголын талын хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ	2	1,617.0	2	100%	2	1,324.43	81.91%
2	Улаанбаатар хотод Олон улсын шинэ нисэх буудал барих төслийн ашиглалтын өмнөх бэлтгэл ажлыг хангах тоног төхөөрөмж	5	1,130.0	4	50%	1	349.9	30.96%
3	Олон улсын шинэ нисэх буудлын навигацийн тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт	3	560.0	2	60%	3	0	0%
4	Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна ачаа шуудан буулгах ачих талбайн зураг төсөв боловсруулах барилгын ажил	1	593.5	1	100%	1	156.77	26.4%
5	Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахууны агуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх	1	150.0	1	100%	1	0	0%
6	Ландшафт /барилга, байгууламжийн гадна зүлэгжүүлэлт, тохижилт	4	1,414.9	3	75%	3	0	0
<b>Нийт дүн</b>		<b>16</b>	<b>5,465.4</b>	<b>12</b>	<b>85.7%</b>	<b>11</b>	<b>1,831.1</b>	<b>33.5%</b>

Төсөл (1) 2 багц болгон зарлаж 2017 оны 12 сард гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан 2018.9.12-нд гэрээний хугацаа дуусч хүлээлгэн өгсөн ба ажлын гүйцэтгэл 100%, батлагдсан төсвийн 81.9 хувийн санхүүжилтийг олгосон.

Төсөл (2) 5 багц болгон зарласнаас 2018.10.31-ний байдлаар 4 багц ажлыг гүйцэтгэх компанитай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн байна. Үүнд: Олон улсын нисэх онгоцны шинэ буудалд тавилга эд хогшил нийлүүлэх ажлын гүйцэтгэл 30%-тай хэрэгжиж санхүүжилт олгогдоогүй бол Багц-2, Багц-3-ын компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 70%-тай хэрэгжиж ажил хүлээн авах комисс томилогдсон боловч дүн гараагүй санхүүжилт олгогдоогүй байна.

Агаарын хөлгийн шатахуун тээвэрлэх автомашин худалдаж авах 350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 100 хувь хэрэгжиж санхүүжилтийг бүрэн олгосон.

Харин Багц-1 буюу хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендерыг цахимаар зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул 2018.8.15-нд нээлттэй зарлаж 2018.9.17-нд нээсэн, дахин 2018.10.22-нд 3 дахь удаагаа зарласан ба тендер нээх хугацаа болоогүй байна.

Төсөл (3) буюу Олон улсын шинэ нисэх буудлын навигацийн тоног төхөөрөмж болон шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийн 2018 оны санхүүжилтийн 560.0 сая төгрөгийн төсөвт өртөгт хийгдэх 3 багц арга хэмжээний Багц -1 буюу Геосон ХХК-тай байгуулсан шинэ нисэх буудлын навигацийн тоног төхөөрөмжийн шалган баталгаажуулах нислэг Түлхүүр гардуулах нөхцлөөр байгуулж 2018.11.05-нд дуусах ба 2018.10.31-ны байдлаар ажлын явц 60 хувьтай санхүүжилт олгогдоогүй байна.

Шинэ нисэх буудлын шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулах /уламжлалт/ Багц-2 техникийн шаардлагад нийцэх өөр компани байхгүй тул “МИАТ” ТӨХК-тай шууд гэрээ байгуулан ажил дууссан 100 хувийн хэрэгжилттэй гэх боловч комиссын дүгнэлт гараагүй санхүүжилтийг олгоогүй байна.

Олон улсын шинэ нисэх буудлын шинээр зохиогдох нислэгийн журмыг шалгалтын нислэгээр шалган баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт /PBN/ Багц-3-т шалгаруулалтад шаардлага хангасан тендер ирээгүй ба дотоодын авиа компаниуд гүйцэтгэх боломжгүй тул БНХАУ-ын компанитай хэлцэл хийж шууд гэрээ байгуулахаар болсон байна.

Төсөл (4) Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна ачаа, шуудан буулгах, ачих талбайн зураг төсөв боловсруулах, барилгын ажилд нээлттэй тендер зарлан сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан ба ажил гүйцэтгэх гэрээний хугацаанд ажлаа хүлээлгэн өгөх тухай албан бичгийг ирүүлсэн байна. Санхүүжилтийн 33.4 хувийг олгосон ба ажил хүлээж авах комисс томилогдон ажиллахаар болсон байна.

Төсөл (5) Олон улсын шинэ нисэх буудлын шатахууны агуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх ажлын тендерийн хураангуй жагсаалтыг гарган бичиг баримтыг үнэлэх шатандаа явж байна.

Төсөл (6) Ландшафт /Барилга, байгууламжийн гадна зүлэгжүүлэлт, тохижилт/ 1,414.9 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй төсөл арга хэмжээ 4 багцад хуваан тендер зарласнаас Багц-1-ын Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний гадна тохижилт, Багц-2-ын Захиргааны барилгын гадна тохижилт, Нисэх буудлын үйлчилгээний барилгын гадна тохижилтын төсөл арга хэмжээний ажилд сонгогдсон гүйцэтгэгчтэй 1,206.6 сая төгрөгийн төсвөөр гэрээ байгуулан ажил дууссан үндэслэлээр комисс томилогдон ажиллаж байх боловч санхүүжилт олгогдоогүй.

Харин Ландшафтын зураг төсөл боловсруулах гэсэн зөвлөх үйлчилгээний ажилд 2 удаа нээлттэй тендер зарлаж шаардлагад нийцсэн нэг ч тендер ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүх тендерээс татгалзаж дахин цахимаар нээлттэй зарлаж хураангуй жагсаалтыг гаргасан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул гэрээ шууд байгуулах тухай зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих дээрхи 6 төсөл арга хэмжээний 85.7 хувьд сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, гэрээт ажлын гүйцэтгэл 61.6 хувьтай байх боловч батлагдсан санхүүжилтийн 33.5 хувийг олгосон байна.



**2.2. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хэрэгжих төсөл арга хэмжээ**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 209 дүгээр тушаалаар ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна. ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон цэвэр ашиг болох 9,330.98 сая төгрөгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 2017 онд уламжлалт аргаар, 2018 онд цахимаар нээлттэй зарлаж хэрэгжүүлсэн байна.

**ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл**

№	Төсөл арга хэмжээний нэр	Төлөвлөсөн			Гэрээ байгуулсан		Гүйцэтгэл		Ажлын гүйцэтгэл хувь
		Төсөл тоо	багц	өртөг	тоо	дүн	Төсөл тоо	Санхүүжилт	
1	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	8	9	6,970.9	8	6,541.41	8	4,417.31	67.5%
2	Тоног төхөөрөмж авах	13	15	1,650.1	12	1,161.1	12	1,121.83	92.3%
3	ТЭЗҮ, зураг төсөл зохиох, зөвлөх үйлчилгээ	4	4	196.0	4	189.63	4	20.80	69%
4	Их засвар	3	3	213.9	2	41.38	2	16,15	53%
5	Сургалт	1	1	300.0	1	300.0	1		100%
<b>Нийт дүн</b>		<b>29</b>	<b>32</b>	<b>9,330.9</b>	<b>27</b>	<b>8,233.5</b>	<b>27</b>	<b>5,576.1</b>	<b>72%</b>

2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас нийт 9,330.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төрлийн 29 төсөл арга хэмжээг 32 багцад задлан нээлттэй тендер зохион байгуулсан байна. Эдгээрээс 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх сонгогдсон гүйцэтгэгчтэй 8,233.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Гэрээний үүргийн хэрэгжилт, төслийн явцыг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	Ажлын тоо	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Санхүүжилт гүйцэтгэл		Нийт санхүүжилт	Хувь
				2017 он	2018 он		
Бүрэн хэрэгжсэн	20	1,921.40	1,752.78	812.77	569.35	1,382.12	78.8%
Шууд гэрээ байгуулах зөвлөмж өгсөн	1	291.00					
Тендерийн баримт бичиг боловсруулах шатанд	1	163.60	-				
Ажил дуусаж хүлээж авах шатанд байгаа	2	75.00	74.38				
Гэрээ байгуулагдан ажил гүйцэтгэж байгаа	4	6,519.90	6,406.34	-	4,193.97	4,193.97	65.5%
Тендер амжилтгүй болсон	1	360.00	-				
<b>Нийт дүн</b>	<b>29</b>	<b>9,330.90</b>	<b>8,233.50</b>	<b>812.77</b>	<b>4,763.32</b>	<b>5,576.09</b>	<b>67.7%</b>

Дээрх хүснэгтээс харахад ажил нь бүрэн дуусч гэрээг дүгнэсэн 20 төсөл арга хэмжээ, гэрээг дүгнэх шатандаа байгаа 1 төсөл арга хэмжээ, ажил гүйцэтгэж байгаа 4 төсөл, арга хэмжээ байна.

2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 27 гүйцэтгэгчтэй байгуулсан 8,233.5 сая төгрөгийн гэрээт ажлын 20 ажил буюу 74.1 хувь бүрэн хэрэгжиж батлагдсан төсвийн 78.8 хувийг олгосон бол 2 ажил хүлээж авах шатандаа, 4 ажил гэрээний хугацаа дуусаагүй 65.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Тайлант хугацаанд нийт төсөл хөтөлбөрт гэрээний үнийн дүнгийн 5,576.1 сая төгрөг буюу 67.7 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Харин гэрээ байгуулагдаагүй, ажил нь эхлээгүй 4 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Цахилгаан станцын үнс ачигч ковш 2 ширхэгийг худалдан авах арга хэмжээний тендерийг 2017 онд хоёр удаа уламжлалт аргаар нээлттэй, 2018 онд 2 удаа цахимаар зарлаж амжилтгүй болсон. Гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын албан хаагчдын спорт цогцолбор, хүүхдийн цэцэрлэгийн зураг, төсөв- Зөвлөх үйлчилгээний тендерийг цахимаар зарласан. Хурангуй жагсаалтыг гарган урилга өгсөн. Шалгаруулалт дуусаагүй байна.

3. Нисэх буудлуудын засвар /Орон нутагт/- Тендерийн сонгон шалгаруулалтыг 3 багц болгон зарлаж нээсэн. Нэг ч оролцогч оролцоогүй. Дахин зарлах болсон байна.

4. Автомашины гаражийн барилга, 50 ширхэг /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/- Тендерийг 2017 онд хоёр удаа уламжлалт аргаар нээлттэй, 2018 онд 2 удаа цахимаар нээлттэй зарлаж амжилтгүй болсон. Нээлттэй үнийн санал авах урилгыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тавьж үнийн саналыг авсан. Үнэлэх шатандаа байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тусгагдсан Завхан аймгийн Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажил 2008 оноос эхэлсэн, гэрээний анхны үнэ 8,651.5 сая төгрөг байсан боловч гэрээнд нийт 8 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, сүүлийн гэрээний хугацаа 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дууссан байна. Уг ажилд үнийн өсөлтөөр 2 удаа нийт 2,242.5 сая төгрөгийг олгохоор зааж, нийт төсөвт өртөг 10,894.0 сая төгрөг болж гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК-д нийтдээ 8,327.2 сая төгрөг буюу гэрээний анхны үнийн дүнгийн 96.2 хувийн санхүүжилт олгосон боловч, барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байсан.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас Завхан аймгийн “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг үргэлжлүүлж дуусгах талаар 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ИНЕГ-т чиглэл өгснөөр “Хурдын зам” ХХК-тай дахин гэрээ байгуулахаар болж “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас байгуулах ажлыг дуусгахад шаардлагатай түүхий эд материал, тээврийн цалингийн өсөлт зэргийг тооцоолж гэрээний үнийг гарган дахин нэмэлт гэрээ байгуулсан байна. Дахин гэрээ байгуулахад гэрээний үнийг 1,893.71 сая төгрөгт хийхээр хүлээн зөвшөөрч нэг талаас ИНЕГ, нөгөө талаас “Хурдын зам” ХХК-ний хооронд 2018.05.30-ны өдөр ИНЕГ.ТББ/БУ-55-07 гэрээний үргэлжлэл, нэмэлт өөрчлөлтийн гэрээ хийсэн байна. Гэрээнд: Гүйцэтгэгч Завхан аймгийн “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас байгуулах ажлыг 2018.06.11-ний өдөр эхэлж 2018.10.30-нд

ашиглалтад оруулахаар зааж Голомт банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн 2018.07.27-нд 1.0 тэрбум төгрөг олгожээ. Гэвч 2018.10.31-ны байдлаар ажил дуусаагүй байна.

Автомашинь гаражийн барилга /50 автомашины багтаамжтай/ 291.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 2 удаа үнэлгээний хороо байгуулж, нийт 4 удаа нээлттэй тендер зарласан боловч амжилтгүй болсон тул үнэлгээний хорооноос гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна.

### 2.3. Урсгал зардлаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны урсгал зардлын хөрөнгөөр санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 2018 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан байна. Төлөвлөсөн худалдан авалтыг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Төлөвлөсөн		Гэрээ байгуулсан		Гүйцэтгэл		Ажлын гүйцэтгэл хувь
		Төсөл тоо	өртөг	тоо	дүн	Төсөл тоо	Санхүүжилт	
1	Хангамж, бараа материал	8	4,099.37	3	3,246.61	1	1,437.73	
2	Аэродромын түүхий эд материал	5	608.84	3	197.49			
3	Хөдөлмөр хамгаалал нормын хувцас	5	294.05	2	41.21			
4	Шалгалтын нислэг /3 багц /	4	1000.0	1	399.0	1	133.0	
5	Даатгалын үйлчилгээ /	12	3,096.63	9	1,612.5	1	28.61	
6	Бусдаар гүйцэтгүүсэн ажил, үйлчилгээ	8	2,009.47					
7	Барилга байгууламжийн засвар	7	267.91	5	159.93			
8	Програм хангамж	2	90.50	2	88.00		47.03	
9	Аэродромын урсгал засвар	2	219.0	2	197.91			
10	Техник хангалт, навигацийн тоног төхөөрөмжийн сэлбэг /	22	2,603.13	18	2,305.51	2	76,65	
	<b>Нийт дүн</b>	<b>75</b>	<b>14,288.9</b>	<b>45</b>	<b>8,248.16</b>	<b>5</b>	<b>1,723.02</b>	

Урсгал үйл ажиллагаанаас нийт 14.3 тэрбум төгрөгийн 51 төсөл арга хэмжээг 75 багцад хуваан 2017 онд уламжлалт аргаар, 2018 онд цахимаар нээлттэй тендер зарлан хэрэгжүүлсэн байна.

Үүнээс 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 45 багц ажлын сонгогдсон гүйцэтгэгчтэй 8,248.2 сая төгрөгийн гэрээ байгуулан 5 ажлын гүйцэтгэлд 1,723.02 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс ажил дуусаж гэрээг дүгнэсэн 4, ажил хүлээн авч байгаа 6, ажил гүйцэтгэж байгаа 35 төсөл арга хэмжээ байна. Харин гэрээ байгуулаагүй 30 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Тендерийг 2 удаа нээлттэй зарласан, сүүлийн зарласан тендерийн нээх хугацаа болоогүй **7** төсөл арга хэмжээ
- Нээлттэй тендерийг 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй үндэслэлээр дахин зарлахаар болсон **3** төсөл арга хэмжээ,
- Нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан шаардлагад нийцсэн тендер ирээгүй **3** төсөл, харьцуулалтын аргаар 2 удаа зарлаад нэг ч тендер ирээгүй **4** төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн **6** төсөл

- Нээлттэй зарлаад хугацаанд нь нээгээд үнэлгээ хийж байгаа 6 төсөл
- Тендер амжилтгүй болсон тендер 3 төсөл арга хэмжээ,
- Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гарч тендерийг түдгэлзүүлсэн 2 төсөл арга хэмжээ,
- Гэрээ байгуулах эрх олгосон боловч гэрээ байгуулахаас татгалзсан 1 төсөл арга хэмжээ байна. Урсгал зардлаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

### **Гурав. “Чингис хаан” Олон улсын нисэх буудал**

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь 2018 онд үйл ажиллагааг нь хэвийн тасралтгүй явуулах, үйлдвэрлэлийн бэлэн байдлыг хангаж ажиллахад шаардлагатай бараа материал, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу зохион байгуулсан байна.

“Чингис хаан” ОУНБ-ын 2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө 2018 оны 8 дугаар сарын 08-нд батлагдсан байна. Ерөнхий төлөвлөгөөнд 2,229.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр бараа, түүхий эд, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 4 төрлийн 24 бүлгийн 118 зүйлийн худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Үүнд: Бараа ажил үйлчилгээний босго үнээс шалтгаалан “Нээлттэй тендер шалгаруулалтын арга”-аар 6 худалдан авалтыг, “Харьцуулалтын арга”-аар 52 бараа үйлчилгээний худалдан авалтыг, “Шууд худалдан авалт”-аар 70 худалдан авалтыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу нийт 128 багцад хуваан зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Нээлттэй тендер шалгаруулалтаар хийх 541.3 сая төгрөгийн худалдан авалтыг ИНЕГ-аас зохион байгуулж, харин харьцуулалтын арга болон шууд худалдан авалтаар зохион байгуулах 1,687.7 сая төгрөгийн худалдан авалтыг “Чингис хаан” ОУНБ-ын захирлын тушаалаар ажлын хэсэг томилон зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт” болон Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 сарын 08-ны өдрийн 23 дугаар тушаалын дагуу “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих” зорилгоор шалгуур шаардлагыг хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгч нартай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

2018 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар дотоодын үйлдвэрлэгчдээс 473.7 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүн худалдан авсан байна.

Тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй 3 төрлийн худалдан авалтыг хийсэн нь төлөвлөлт оновчгүй байгааг харуулж байна. Үүнд: 394.5 м2 хивсийг Захирлын 2018.09.14-ны өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг харьцуулалтын аргаар Натурал текстайл групптэй гэрээ байгуулан худалдан авсан ба гэрээ, гэрээний үүргийн хэрэгжилт, хүлээж авсан актыг хавсаргаагүй байна.

Харин “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд хөрөнгө оруулалтын зардал батлагддаггүй тул үндсэн хөрөнгийн шинж чанартай бараа бүтээгдэхүүнийг Иргэний нисэхийн ерөнхий газраар дамжуулан худалдан авалтыг хийдгээс үйлчилгээний байгууллагын хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай яаралтай худалдан авалт удааширч үйлчилгээний чанарт эрсдэл үүсгэх магадлалтай.

“Чингис хаан ОУНБ” ТӨҮГ нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасан “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд оролцдог*”, 16 дугаар зүйлийн 16.4-д зааснаар “*Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг*” гэсэн хуулийн заалтад нийцэж байх тул тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажиллах нөхцлийг хуулийн хүрээнд зохион байгуулж шийдвэрлүүлэх шаардлагатай.

### **Дүгнэлт**

1. Зам, тээврийн хөгжлийн яамнаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 342,984.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80,796.9 сая төгрөгөөр санхүүжих 79 төсөл арга хэмжээг 83 багцад задалж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 57 буюу 68.7 хувийг, тендер шалгаруулалтын онцгой журмын хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар 10 буюу 12.0 хувийг, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар 13 буюу 15.7 хувийг, мөн тендер шалгаруулалтын онцгой журмын шууд гэрээ байгуулах аргаар 1 буюу 1.2 хувийг, Азийн хөгжлийн банкны худалдан авалтын журмаар 2 буюу 2.4 хувийг зохион байгуулсан байна.

2. 2018 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог оны эхний хагас жилд 82.3 хувийг, сүүлийн хагас жилд 17.7 хувийг байгуулсан байна.

3. Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний сонгогдсон гүйцэтгэгч нартай нийт 59 гэрээ байгуулснаас 2018 оны эхний хагас жилд 29 буюу 49.1 хувийг, 3 дугаар улиралд 27 буюу 45.8 хувийг, 4 дүгээр улиралд 6.8 хувь буюу 4 гэрээ байгуулах эрхийг олгосон өөрөөр хэлбэл оны сүүлийн хагас жилд нийт гэрээний 51.7 хувьд гэрээ байгуулах эрх олгож худалдан авах ажиллагааг зохион байгуулж худалдан авалтыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна. Мөн хяналт шалгалтад хамрагдсан тайлант хугацаа буюу 11 сарын байдлаар гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй 23 төсөл арга хэмжээ байгаа нь худалдан авалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

4. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол Сангийн яаманд 5 удаа, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2 удаа нийт 7 гомдол гарсан байна.

5. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 83 дугаар тушаалаар Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээ /Засгийн газрын 2015 оны 313 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх авто зам/ -ний жагсаалтыг баталсан байна. Батлагдсан

жагсаалтаас 2018 онд 5,465.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг ИНЕГ-т хариуцуулан хууль журмын дагуу зохион байгуулахыг даалгасан байна.

Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Монголын талын гүйцэтгэх төсөл арга хэмжээний жагсаалтаас Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 191 дүгээр тушаалаар 2017 онд ИНЕГ-т 5,440.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,895.4 сая төгрөгөөр санхүүжих 4 төрлийн 11 төсөл арга хэмжээг хариуцуулснаас шалгарсан байгууллагатай тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулаагүйгээс барилгын гадна талбайн 570.2 сая төгрөгийн ландшафтын ажлууд хийгдээгүйгээс Засгийн газрын хүлээх үүргийн биелэлт, зээлийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байхад хүргэсэн гэсэн зөрчил ҮАГ-ын 2017 оны гүйцэтгэлийн аудитаар илэрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих дээрх төсөл арга хэмжээнд 2018 онд мөн 570.2 сая төгрөгийн төсөв батлагдан дахин тендер зарласнаар 2018.07.20-нд 361.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд сонгогдсон компанитай гэрээ байгуулж ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний, захиргааны барилгын, нисэх буудлын үйлчилгээний барилгын гадна тохижилтын ажил 2018.09.25 гэхэд бүрэн дууссан боловч 2018.10.31-ний байдлаар гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоогүй байна.

Харин Ландшафтын зураг төсөл боловсруулах, /гадна зүлэгжүүлэлт, тохижилт/-ын 208.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд 3 удаа нээлттэй тендер зарлаад шаардлагад нийцсэн нэгч тендер ирээгүй гэх шалтгаанаар гэрээ байгуулагдаагүй байх тул энэ тайлангийн хугацаанд хийгдэх магадлал бага байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зам, тээврийн салбарт 2018 онд хэрэгжих хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 59 гэрээг ангилж харвал, 2 ба түүнээс дээш тендерт шалгарч гэрээ байгуулсан 7 аж ахуйн нэгж байна. Аж ахуйн нэгжүүд боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцөөр хангагдсан байж болох ч 2 ба түүнээс дээш арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд техникийн болон боловсон хүчний нөөцийн хуваарлалтад хүндрэлтэй, хэрэгжилт удаашрах, төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд үр дүнгээ өгөхгүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах магадлалтай байна.

Тухайлбал: “ЗМЗ”, “Асгат кент”, “Жол” ХХК –иуд тус бүр 3 төсөл арга хэмжээнд, “Тэргүүн саруул”, “Анандын зам”, “Их богд зам”, “Цэлмэг зам” ХХК- иуд тус бүр авто замын 2 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 269 дүгээр тушаалаар батлагдсан ЗТХЯ-ны 2018 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө”-гөөр 35 арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 79 төсөл хэрэгжсэн ба төлөвлөсөн төсөл хугацаандаа хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- *Хорооллын доторх авто замын засвар /Улаанбаатар БГД-ийн 1, 2, 3, 4 дүгээр хорооны байруудыг холбосон зам 03, 60, 33, 34, 7-3, дугаар байр, 479,72, 64, 65, 66, 76 дугаар байр, 2а, 3а, 52 дугаар байр/ үнэлгээний хороо байгуулахад 85 хоног, гэрээ байгуулахад 86 хоног*
- *Аймгийн төвийн авто замын өргөтгөл, шинэчлэлт 10.4 км / Баян-Өлгий Өлгий сум / үнэлгээний хороо байгуулахад 50 хоног, гэрээ байгуулахад 97 хоног*
- *Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн авто замын төгсгөлийн хатуу хучилттай зам 22 км /Булган/ үнэлгээний хороо байгуулахад 50 хоног, гэрээ байгуулахад 66 хоног*
- *Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий Улаанхус сум/ үнэлгээний хороо байгуулахад 50 хоног, гэрээ байгуулахад 88 хоног гэх мэтээр бүх төслийн хугацааг хэтрүүлж зохион байгуулсан байна.*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд ЗТХЯ-нд хэрэгжих 64 төсөл арга хэмжээнээс 2018 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар 22 төсөл арга хэмжээ буюу 34.4 хувь нь гэрээ байгуулагдаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээнээс Иргэний нисэхийн ерөнхий газраас зохион байгуулсан 6 төрлийн 16 багц ажлыг цахимаар нээлттэй зарлаж хэрэгжүүлснээс 2018 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 11 багц ажил хэрэгжиж 1,831.1 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ. Энэ нь нийт санхүүжилтийн 33.5 хувь нь болж байна. Эдгээрээс бүрэн хэрэгжиж дууссан 1 төсөл арга хэмжээ, комисс ажиллан хүлээж авах шатандаа байгаа 8 төсөл арга хэмжээ, ажил үргэлжлэн хийгдэж байгаа 2 төсөл арга хэмжээ байна.

ИНЕГ-ын 2016 оны цэвэр ашгаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх 29 төсөл арга хэмжээнээс 20 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж 1 төсөл арга хэмжээ хүлээж авах шатандаа, 4 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулаагүй байна. Нийт санхүүжилтын 67.7 хувийг олгосон байна.

### **Зөвлөмж**

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг тухайн оны 1 улиралдаа багтаан зохион байгуулж төлөвлөсөн хугацаандаа гэрээ байгуулж тайлант ондоо хэрэгжүүлэх;

Ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг сайжруулах, гэрээний үүргийн хэрэгжилт болон, авто замын хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж, хариуцлагын тогтолцоог бий болгох;





Гэрээний үүргийн хэрэгжилтэнд гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж, гүйцэтгэлийн бодит үр дүнгээр санхүүжилтийг хийх;

Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл,

арга хэмжээг тусгана” гэсэн шаардлагад нийцүүлэн зураг төсөвгүй, зураг төсөв нь баталгаажаагүй, техникийн нөхцөл авагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх;

Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-д заасны дагуу тендерийн хавтаслахад Худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай тайлбар тодорхойлт, нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга сонгосон тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл, тайлбар, тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, тендер шалгаруулалт амжилтгүй болсон эсвэл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл, гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр, гэрээ, худалдан авах бараа, ажил үйлчилгээний тухай товч тодорхойлт, техникийн баримт бичиг, захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичгүүд, тендер оролцогчдоос ирүүлсэн тендерийн материалууд, тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг, гэрээг дүгнэж бараа ажил үйлчилгээг хүлээж авсан баримтуудыг тендерийн хавтаст хэрэгт бүрэн оруулж архивлах шаардлагатай.

ТАНИЛЦСАН:

ЗТХ-ИЙН САЙД		Я.СОДБААТАР
ДЭД САЙД		Л.ХАЛТАР
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА		С.БАТБОЛД
ТЗУГ-ЫН ДАРГА		Ж.ГАНТӨМӨР

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /СХШУАБ/ 



Л.ОЮУНБИЛЭГ